



ДАРХАН-УУЛ АЙМАГ
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2023 оны 04 сарын 08 өдөр

Дугаар 01-А/81

Дархан

Гамшигаас хамгаалах бэлэн байдлын
үзлэг зохион байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 66 дугаар зүйлийн 66.1, Гамшигаас хамгаалах тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.4, 27¹ дүгээр зүйлийн 27¹.1.3. 32 дугаар зүйлийн 32.1.1, 32.1.8 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь :

1. Гамшигаас хамгаалах иж бүрэн сургууль, стратегийн команд штабын сургуулийн бэлтгэл ажлыг хангах, аймгийн гамшигаас хамгаалах алба, мэргэжлийн анги, төрийн болон төрийн өмчтэй байгууллагын томилгоот бүрэлдэхүүний бэлтгэл, бэлэн байдлыг дээшлүүлэх зорилгоор "Гамшигаас хамгаалах бэлэн байдлын үзлэг"-ийг 2023 оны 04 дүгээр сарын 03-ны өдрөөс 04 дүгээр сарын 24-ний өдрийг хүртэлх хугацаанд зохион байгуулсугай.

2. Гамшигаас хамгаалах бэлэн байдлын үзлэг зохион байгуулах ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг нэгдүгээр, хэрэгжүүлэх ажлын хуваарийг хоёрдугаар, удирдамжийг туравдугаар, шаардагдах зардлыг дөрөвдүгээр хавсралтаар тус тус баталсугай.

3. "Гамшигаас хамгаалах бэлэн байдлын үзлэг"-т томилгоот бүрэлдэхүүнийг бүрэн хамруулахыг аймгийн Гамшигаас хамгаалах алба, мэргэжлийн анги, сумдын Ерөнхий зориулалтын мэргэжлийн дарга наарт үүрэг болгосугай.

4. Шаардагдах 232,254 (хоёр зуун гучин хоёр мянга хоёр зуун тавин дөрөв) төгрөгийг аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөөс шийдвэрлэхийг Санхүү, төрийн сангийн хэлтэс (Б.Жаргалсайхан)-т зөвшөөрсүгэй.

5. Нэгдсэн арга хэмжээний тайлан мэдээг нэгтгэн 2023 оны 04 дүгээр сарын 26-ны өдөр аймгийн Засаг даргад танилцуулахыг Онцгой байдлын газар (хурандаа С.Пүрэвсамдан)-т даалгасугай.

6. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын орлогч (Б.Жавхлан)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА

Б.АЗЖАРГАЛ

Захирамж-1 2023

.. 4523010337